

**УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ  
НЭР БҮХИЙ АРВАН АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗЭД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ  
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН-2023 он**

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны а/52 тоот тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд нэр бүхий арван телевизэд хийсэн төлөвлөгөөт хяналт, шалгалт

2023 он

**1. Ерөнхий зүйл**

Тус хорооноос Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нэр бүхий дөрвөн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, техник, стандарт хангасан байдал, аюулгүй ажиллагаа, Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдалд болон тус Хорооны даргын 2022 оны А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн хяналт шалгалтаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нэр бүхий зургаан телевизэд түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг шалгах гүйцэтгэлийн шалгалтыг 2023 оны 03-р сарын 03-ны өдрөөс 07-ны өдрүүдэд болон 06-р сарын 14-ны өдрөөс 20-ны өдрүүдэд хийж гүйцэтгэж ажиллаа.

**2. Ажлын хэсгийн гишүүд:**

Ажлын хэсэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын (ӨНЗГ) дарга Э.Золбаяр, Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн (ЗХХ) дарга Н.Тогтохсүрэн, ЗХХ-ийн ахлах мэргэжилтэн С.Машбат, ЗХХ-ийн мэргэжилтэн Б.Алтай, ЗХХ-ийн мэргэжилтэн Г.Ганчимэг, ӨНЗГ-ийн мэргэжилтэн М.Эрдэнэцэцэг, жолооч М.Сумъяа нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

**3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж**

Өргөн нэвтрүүлгийн дуу, дүрсийн гаралтын чанар Tektronix WFM2300 хэмжүүрийн багаж ашиглав.

**4. Шалгалтад хамрагдсан телевизүүд**

Шалгалтанд хамрагдсан телевизүүдийн тусгай зөвшөөрлийн ангилал: Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх

№	Эзэмшигч	Телевизийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хамрах хүрээ	Шалгалт хийсэн өдөр
1	Мон зах ХХК	ONTV	12900123	2023.04.23	Монгол Улс	2023.03.03
2	Монвсат нэтворк ХХК	Монголсат	12900338	2027.02.27	Улаанбаатар хот	2023.03.03

3	Эн би жи кинг монголиа ХХК	Нийслэл	12900021	2023.05.31	Монгол Улс	2023.03.06
4	Эм Ви Эс ХХК	Mon Plus	12900012	2023.05.06	Улаанбаатар хот	2023.03.07
5	Форчун глобал ХХК	Глобал	12900018	2023.05.06	Монгол Улс	2023.03.07
6	Эс Си Эйч ХХК	Суваг 1	12900027	2023.06.27	Монгол Улс	2023.03.07
7	Эгон ХХК	ШОП Монголиа /теле-худалдаа/	12900106	10/25/2023	Монгол Улс	2023.06.20
8	Эм Ди Энтертэйнмент ХХК	TV2	12900344	12/18/2027	Монгол Улс	2023.06.13
9	Төгс барчин хангай ХХК	Цахим монгол ТВ	12900345	2/28/2028	Улаанбаатар хот	2023.06.20
10	Хөгжил телевиз ХХК	Хөгжил	12900091	5/25/2027	Монгол Улс	2023.06.14

## 5. Ажлын хэсгийн хийж гүйцэтгэсэн ажлууд

*5.1 Хорооны даргын А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн хяналт, шалгалтын хүрээнд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн хугацаатай үүрэг даалгаварын биелэлтийг шалгуулсан үйлчилгээ эрхлэгчид*

Хорооны даргын А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн хяналт, шалгалтын дүнгээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нэр бүхий 6 телевизэд илэрсэн нийтлэг зөрчил нь “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль”-ийн 19.2.1, 31.3.3 дах заалтууд, “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.1, 3.4, 3.17,4.1 дэх заалтууд, “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3.1.4, 3.15, 3.16, 3.18 дах заалтууд, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.3, 3.10, 3.18 дах заалтууд байсан. Хяналт шалгалтын ажлын хэсэг тус шалгалтын тайланг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 4-р улиралд Даргын зөвлөлд, Хорооны хуралдаанд танилцуулсны үндсэн дээр 2022.12.22-ны 71 тоот тогтоолоор 60 хоногоор тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

Тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлсэн хугацаанд тус Хорооноос зөрчлүүдийг арилгах тухай хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн.

Хяналт, шалгалтын ажлын хэсэг 2023 оны 03-р сарын 03-ны өдрөөс 07-ны өдрүүдэд нэр бүхий 6 телевизэд ( Монвсат нэтворк ХХК-ийн Mongolsat телевиз, Эм Ви Эс ХХК -ийн MonPlus, Форчун глобал ХХК-ийн Глобал телевиз, Эн Би Жи Кинг Монголиа ХХК-ийн Нийслэл телевиз, Эс Си Эйч ХХК -ийн Суваг 1, Монзах ХХК-ийн ONTV телевиз ) өгсөн хугацаатай үүрэг даалгаварын биелэлтэд гүйцэтгэлийн шалгалт хийхэд дээрх зөрчлүүдийг арилгаж редакцын бодлого дүрэм баталсан, өөрийн бүтээлийн хувь

хэмжээ нэмэгдсэн, хүний нөөцийн боловсон хүчний тушаал шийдвэр хөдөлмөрийн гэрээг хийсэн, редакцын бодлогодоо хүүхдийг зохисгүй агуулагаас хамгаалах тухай, үзэгчдээс санал, гомдол хүлээж авч шийдвэрлэх тухай тусгасан байна.

Студи, техникийн хувьд телевизийн онцлогт тохирсон нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулахад шаардагдах техникийн иж бүрдлийг хангасан Монгол Улсын стандартын MNS 5592-1, MNS 5592-2 стандарт норм нормативд нийцүүлсэн байна.

Иймд хугацаатай үүрэг даалгаврыг биелэлтийг хангасан гэж үзэж Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын зөвлөлийн хурал, Хорооны хуралд танилцуулан Хорооны 2023.03.17-ны 26 тоот тогтоолоор Суваг 1, ONTV, MongolSat Кино, Глобал телевизийн тусгай зөвшөөрлийг, 2023.04.21-ний 37 тоот тогтоолоор Нийслэл ТВ, MonPlus телевизийн тусгай зөвшөөрлийг тус тус сэргээв.

### *5.2 Тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалгуулсан үйлчилгээ эрхлэгчид*

Уг төлөвлөгөөт ажлын хүрээнд хийсэн хяналт, шалгалтад хамрагдсан 4 телевизэд хөтөлбөрийн хувьд нийтлэг илэрсэн дутагдал нь өөрийн бүтээл үйлдвэрлэл хангалтгүйн улмаас өөрийн бүтээлийн хувь хэмжээ “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.4 заалтыг хангахгүй байгаа ба арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн хөтөлбөрийн нийт цагийн 15%-с илүүгүй байх гэсэн нь “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.10 дах заалтыг хангахгүй байна.

Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй 3 телевизээс 2 телевиз нь хөтөлбөрийн хувьд олон талын мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэдгийн хувьд Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэх нэвтрүүлгийн төлөвлөлтөө гаргаж ирүүлэх, төлөвлөлтийнхөө дагуу нэвтрүүлгүүдээ нэвтрүүлэх үүрэг хангалтгүй байгаа зөрчил дутагдалтай байна. Телевизийн студи, техник стандартын хувьд студийн акустик шаардлага хангахгүй, тоног төхөөрөмжүүдийн хоорондын холболтын сувагчлалыг стандартын дагуу хийгээгүй, кабелиудын хаягжилт дутуу, техникийн үзлэг үйлчилгээг тогтмол хийдэггүй, дуу дүрсийн хэмжилт хийдэггүй зэрэг алдаа дутагдалтай байдалтай байна. Дээрх зөрчил, дутагдлуудаа засаж сайжруулах талаар газар дээр нь зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

Хяналт шалгалтаар Эм Ди Энтертэймент ХХК-ийн ТВ2 телевиз нь 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн 02/437 тоот албан бичгээр хүргүүлсэн хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3.1.5 дах заалтыг хангаагүй байсан зөрчлийг арилган өөрийн гэсэн студитэй болж тохижуулсан, “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.4 дэх заалтыг хангахгүй байсан зөрчил болох өөрийн бүтээлийн хувь хэмжээ 2023 оны эхний 4-р сарын байдлаар 12%-тай байсан нь 21%-тай болсон байгаа нь зөрчил

дутагдлыг шат дараатайгаар арилган, хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллаж байна гэж үзэж байна.

Эгөн ХХК-ийн ШОП Монголия /теле-худалдаа/ нь 2022 оны А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн хяналт, шалгалтын хүрээнд “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 4.4 дэх заалтыг зөрчиж байсан нь 2023 оны А/52 тоот тушаал удирдамжийн хүрээнд хийсэн хяналт, шалгалтаар зөрчлийг арилган Шинэ сансар кабель ХХК-тай гэрээ байгуулан 57 суваг дээр байж нэвтрүүлгээ нэвтрүүлж эхэлсэн байна.

## **6. Шалгалтын дүнгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Ажлын хэсэг нь үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гаргаж, зарим үйлчилгээ эрхлэгчдэд буюу үйл ажиллагаагаа нь тогтворгүй, мониторингийн дүнгээр хангалттай бус байгаа Төгс барчин хангай ХХК-ийн Цахим Монгол ТВ, Хөгжил телевиз ХХК-ийн Хөгжил телевизэд тус тус гаргасан зөрчил тус бүрээр дараах зөрчлүүдийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа. Үүнд:

1. “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль”-ийн 31.3.2 дахь заалт нь телевиз нь өөрийн редакцын бодлого, үзэгчдийн гомдол санал хүлээн авч шийдвэрлэх журамтай байх,
2. “Телевизийн нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.10 дахь заалт нь арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нэвтрүүлгийн 15%-иас хэтрэхгүй байх,
3. “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.4-т заалт нь өөрийн бүтээлийн хувь хэмжээ 30%-иас багагүй байх,
4. “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.22.1, 3.22.2, 3.22.3, 3.25 дахь заалт нь телевизийн үйлчилгээг найдвартай, тасралтгүй хүргэхэд техникийн нөхцөлөөр хангасан байх гэсэн нөхцөл шаардлагуудыг биелүүлэн хэрэгжүүлэн ажиллах.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

2023 он